



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/207

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн Биеийн тамир,
спортын хорооны эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 21,543,192.32 (хорин нэгэн сая таван зуун дөчин гурван мянга нэг зуун ерэн хоёр төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хороо (Б.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 22 нэр төрлийн 17,021,009 (арван долоон сая хорин нэгэн мянга ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 6 нэр төрлийн 4,522,184 (дөрвөн сая таван зуун хорин хоёр мянга нэг зуун наян дөрөв) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулсаны орлогын 30 хувь 42,900 (дөчин хоёр мянга есөн зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хороо (Б.Мөнх-Эрдэнэ)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРАА



115050000629

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07 ны өдрийн А/хөдүгээр тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хороо

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	Мэргэжилтний санал	ЭБХХК-ийн хурлын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж													
1	Зурагт	49	ш	1	307,530.00	307,530.00	307,530.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
2	Хөргөгч	51	ш	1	317,101.42	317,101.42	317,101.42	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
3	Компьютер /иж бүрэн/	12	ш	1	699,930.00	699,930.00	699,930.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
4	Компьютер /иж бүрэн/	13	ш	1	1,000,000.00	1,000,000.00	1,000,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
5	Канон	16	ш	1	1,042,300.00	1,042,300.00	1,042,300.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	15,000	15,000
6	Хүчний аппарат	16	ш	1	2,109,615.20	2,109,615.20	2,109,615.20	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	5,000	5,000
7	Гарын шахалт аппарат	16	ш	1	781,725.00	781,725.00	781,725.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	5,000	5,000
8	LCD- дэлгэц	11	ш	2	209,900.00	419,800.00	419,800.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	8,000	8,000
9	Процессор	11	ш	1	549,900.00	549,900.00	549,900.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
10	Процессор	11	ш	1	949,900.00	949,900.00	949,900.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
11	Проектор Dell 1410/	10	ш	1	1,357,300.00	1,357,300.00	1,357,300.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
12	Компьютер /иж бүрэн/	8	ш	4	1,529,000.00	6,116,000.00	6,116,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах